

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ НИЙСЛЭЛД ТӨЛӨӨЛӨН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)
1	2	3	4	5	6
3.1.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:					
1	3.1.1.1.Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;		1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1 2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	Өсвөр насны хүүхэд, оюутан, залуучуудыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдож, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Анзаар-2” аяныг энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс энэ оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 5 сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа ахлах сургууль, Баянгол дүүргийн 10 дугаар хорооны эрсдэлт бүлгийн насанд хүрээгүй 6,425 сурагчдад “Хорт зуршил ба донтолт” сэдэвт 48 удаагийн, их, дээд сургууль, коллежийн 1,002 оюутан, төрийн 6, төрийн бус 18 байгууллагын 1541 ажилчдад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт 24 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, уриалга

					<p>бүхий 34 видео, 16 төрлийн постер, 13 рийл нийт 63 мэдээ, мэдээлэл байршуулахад давхардсан тоогоор 4.5 сая хэрэглэгчдэд хүрсэн.</p> <p>Хүүхдийг хорт зуршлаас урьдчлан сэргийлэх чиглэлээр 517 удаагийн сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 94,905 сурагч, 32,091 иргэнийг хамруулсан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 30,967 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2,900 хэргээр буюу 10.33 хувиар өсөж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 678 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 42 хэргээр буюу 6.6 хувиар өсөж, бүх хэрэгт эзлэх хувийн жин 2.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.16 нэгжээр өссөн.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 316 зөрчлийг шийдвэрлэж, удаа дараа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 314 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлуулах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
2	3.1.1.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.	-	1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	<p>12 дугаар сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас 678 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 42 нэгж 6.2 хувиар өссөн байна.</p> <p>“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн хүрээнд “Зөвлөмж” боловсруулан оролцогч байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>“Томчуудын мэдлэг-Багачуудын бамбай” арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Прокурорын</p>

					<p>газар, Мөрдөн байцаах алба, Урьдчилан сэргийлэх алба, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс, хороодын хамтарсан баг болон “Хөөрхөн зүрх”, “Өнөр бүл төв”, “Good neighbors” төрийн бус байгууллагууд оролцсон “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг энэ оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хамтдаа сэргийлье” арга хэмжээг зохион явуулж, 4 видео шторк бэлтгэн цахим орчинд байршуулж иргэдэд хүргэсэн. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг шийдвэрлэх, зөрчлийн давтамжийг тодорхойлох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр зөрчил үйлдсэн этгээдийг регистрийн дугаараар бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
3	3.1.1.3.Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	-	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна.	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар Гэр бүлд зөвлөгөө өгөх 8 төвөөр дамжуулан 1,731 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээх, гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт нөлөөллийн 322 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 54,829 хүнийг хамруулж, цахимаар 270,251 хүнд хүрсэн байна.

					Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан хүний тоо 15 хувиар, цахим орчинд хүрсэн хүний тоо 116 хувиар тус тус өссөн байна. <i>Хэрэгжсэн</i>
4	3.1.1.4.Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;		1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд 450,000,000 төгрөг, түр хамгаалах байрны үйл ажиллагаанд шаардлагатай төсөвт өртөг болох 754,028,734 төгрөгийг батлуулан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <i>Хэрэгжсэн</i>
3.1.2.Хүүхдийн эрхийн талаар:					
5	3.1.2.1.Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;	-	1.Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	Нийслэлийн 9 дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлүүд хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөөг орон нутгийн хэмжээнд батлан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 85 хувьтай байна. <i>Хэрэгжсэн</i>
6	3.1.2.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн	-	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор урлаг, спорт, техник технологи, математик сэтгэхүй, хэл, илтгэх урлаг зэрэг 7

	хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;		орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь		<p>чиглэлийн 5,923 төрлийн өөрийн сургуулийн болон сургуулиас гадуурх дугуйлан, секц, клубт нийт 187,857 суралцагч, 1,254 суралцагчдын өөрөө удирдлагын оролцооны байгууллагад 33,593 суралцагч буюу нийт 398,437 суралцагчаас 221,450 суралцагч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан бөгөөд нийт суралцагчдын 55.5 хувийг эзэлж байна. Мөн Монгол ёс заншлаас суралцах, өвлүүлэн авч үлдэх зорилгоор сурагчдын зан төлөвийн төлөвшил, уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл, бахархлаа дээдэлж, түүнээс суралцахаар "Би монгол хүүхэд" ёс заншлын наадмыг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд 11 дэх жилдээ зохион байгуулсан бөгөөд 9 дүүргийн 166 сургуулийн 156,928 сурагч, 4,120 багш оролцлоо.</p> <p>Хүүхэд хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 319,301 хүүхэд буюу нийт хүүхдийн 52.7 хувь нь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5,762 буюу 1.8 хувиар өссөн байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
7	3.1.2.3.Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;	16,569090.6	Баталсан төсвийн хэмжээ	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.	<p>Дүүрэг тус бүр "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2025-2026 оны хичээлийн жилд хүн амын тоогоор нийслэлд 2-5 настай нийт 135,582 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаас 124,503 хүүхэд буюу 91.8 хувь нь хамрагдсан.</p> <p>БШУС, ЭМС, ХНХСайдын 2022 оны А/571, А/637, А/218 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр" болон сургуулийн</p>

					<p>өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт давхцалтай томъёологдсон 2 настай хүүхдийн эзэмшвэл зохих агуулгатай харьцуулан khuuhed-khugjil.mn сайтад байршуулж, интеграцчилан хэрэгжүүлэх чиглэлээр 471 арга зүйчийг сургалтад хамруулсан.</p> <p>Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд 15 цэцэрлэгийн 30 багшийг сургагч багшаар бэлтгэж, бэлтгэгдсэн багш нар нь 650 эцэг эх, асран хамгаалагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан.</p> <p>“One Sky” олон улсын байгууллагын “Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих” төсөлд Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийг хамруулахаар хамтын ажиллагааг эхлүүлсэн. <i>Хэрэгжсэн</i></p>
8	3.1.2.4.Орон нутгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог ханган ажиллах;	-	Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	<p>Хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 25 удаагийн хурал, уулзалтыг хурлын танхимаар хангаж, хамтран ажилласан.</p> <p>Хүүхдийн төлөө зөвлөлөөс гаргасан хүсэлтийн дагуу Хан-Уул дүүрэг долоо хоног бүрийн 1 өдөр спорт заалаар үнэ төлбөргүй үйлчилж байна.</p> <p>Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх 4 үйл ажиллагаа зохион байгуулж, 539 хүүхдийг хамруулсан.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран охид, хөвгүүдэд зориулсан “Because I am girls”, “Because I am boy” 2000 охид, хөвгүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулсан.</p>

					<i>Хэрэгжсэн</i>
9	3.1.2.5. “Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.	571,440,348	1.Олон нийтийн байцаагчийн тоо 2.Илрүүлсэн хүүхдийн тоо	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна.	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 214 олон нийтийн цагдаа ажиллаж байна.</p> <p>Олон нийтийн цагдаа нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах зорилгоор цагдаагийн алба хаагчидтай хамтран гэмт хэрэг үйлдэгдсэн хэргийн газрын хамгаалалтад 4, хяналт шалгалтад 1,954 удаа, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн 746 этгээдийг цагдаагийн байгууллага болон холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, гэмт хэрэг, зөрчлийн талаарх 674 мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж, цагдаагийн алба хаагчидтай хамтран 1 гэмт хэрэг, 88 зөрчлийг илрүүлэн, таслан зогсоож, 3,509 аж ахуйн нэгж, байгууллага, 16,650 иргэнд хууль тогтоомжийг таниулах ухуулга, сурталчилгаа хийж, тусгай арга хэмжээнд 281 удаа оролцож, 427 удаагийн сургалтад хамрагдсан.</p> <p>“Хүүхэд хамгаалал-2025” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран нийт 204 албан хаагч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Хүүхэд хамгаалал нэгдсэн арга хэмжээний хүрээнд 417 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, хөдөлмөр эрхлэгч 9 хүүхэд, хараа хяналтгүй 10 хүүхдийг илрүүлж, хорооны хамтарсан багтай хамтарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, эрсдэлт нөхцөлд байгаа 220 хүүхдэд эргэн хяналт хийж, ажилласан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>

3.1.3.Хүүхэд хамгааллын талаар:

10	3.1.3.1.“Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;	-	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна.	<p>Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хөгжлийг дэмжих талаар эцэг эхчүүдэд зориулсан 12 арга хэмжээ зохион байгуулж 928 иргэн албан хаагчийг хамруулж, цахимаар 12,958 хүнд хүрсэн байна.</p> <p>Хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулах 2 төрлийн мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, 8,750 хүнд хүрсэн.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 2025 онд бүтээн байгуулалт хийх сонгон шалгаруулалтад тэнцэн авто зам, явган хүний зам талбайн засвар, шинэчлэл, тохижилтын ажлыг зохион байгуулах эрх авсан 52 аж ахуй нэгж байгууллагын ажилтнуудад хүүхдийн эрх, хамгаалал, эцэг эхийн зөвлөл байгуулах, хууль тогтоомжийн талаарх танилцуулгыг хийснээр дээрх 52 байгууллага хүүхэд хамгааллах бодлоготой болсон.</p> <p>Нийслэлд 230,600 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 541 байгууллага Хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлж байгаа нь 0.23 хувьтай байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
11	3.1.3.2.Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж,	-	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	<p>“Хүүхэд хамгаалал-2025” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран нийт 204 албан хаагч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Хүүхэд хамгаалал нэгдсэн арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд байгаа 220 хүүхэд эргэн хяналт хийж, 417 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, хөдөлмөр эрхлэгч 9 хүүхэд, хараа хяналтгүй 10 хүүхдийг илрүүлж, хорооны</p>

	мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;				хамтарсан багтай хамтарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан. <i>Хэрэгжсэн</i>
12	3.1.3.3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;	-	1.Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2.Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд 350 хүүхэд бүртгэгдсэн. Үүнээс гэрч хүүхэд 56, хохирогч хүүхэд 130, сэжигтэн хүүхэд 13, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд 8, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд 74, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүүхэд 3, зөрчил гаргасан хүүхэд 33, ял хойшлуулсан хүүхэд байхгүй байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос боловсролын үйлчилгээ 18, Хууль зүйн туслалцаа үйлчилгээ 98, Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ 114, Эрүүл мэндийн үйлчилгээ 40, Нийгмийн халамжийн үйлчилгээ 25, Иргэний бүртгэлийн үйлчилгээнд 3 хүүхэд хамруулж, нийт 298 хүүхдэд үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөгөө гаргаж, үйлчилгээг хүргэсэн. Нийт бүртгэгдсэн хүүхдийн 85%-д нь үйлчилгээ үзүүлсэн байна. <i>Хэрэгжсэн</i>
13	3.1.3.4.Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй	-	1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна.	Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавих ажлын хүрээнд Налайх, Багануур, Баянзүрх, Багахангай, Сонгинохайрхан

	байдлыг хангаж, хяналт тавих;				<p>дүүргүүдэд хяналт шалгалтын ажил зохион байгуулж ажилласан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 9 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан ба шалгалтын хүрээнд:</p> <p>-“Хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа, зохион байгуулахыг хориглох тухай” дүүргийн Засаг даргын захирамж гаргаж зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>-Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдахаар төлөвлөж байсан 2 үсэргээ, сунгааг таслан зогсоож, зөвлөмж хүргүүлж ажилласан.</p> <p>-Захирамжийг зөрчин азарга, их нас, соёолон, хязаалан насны 120 гаруй морь, 45 уралдаанч хүүхдийг хамруулан үсэрээ сунгаа зохион байгуулсан зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн.</p> <p>-Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй морин спорт уяачдын 4 холбоотой уулзалт зохион байгуулж, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газрын тогтоол, Засаг даргын захирамж, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмж өгч ажилласан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
14	3.1.3.5.Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний	-	Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	<p>Нийслэлийн хэмжээнд болзошгүй аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед болон барилга байгууламж, дэд бүтэц эвдэрч сүйдсэн үед сэргээн босгох үйл ажиллагааг дээрх төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, шаардлагатай зардлыг тухай бүр нийслэлийн Онцгой комисс, Засаг даргын шийдвэрээр Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх, нийслэлийн нөөц боломжоос</p>

	төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;				<p>давсан тохиолдолд Улсын Онцгой комисст хандаж шийдвэрлүүлэхээр тусгасан.</p> <p>Уг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнүүд нь “Аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх”, “Тохиолдсон үеийн хариу арга хэмжээ” болон “Гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээ”-ний төлөвлөгөө гэсэн 3 үндсэн хэсэгтэй бөгөөд болзошгүй гамшгийн нөхцөл байдал үүссэн үед тухайн төлөвлөгөөг удирдлага болгон ажилласан.</p> <p>Дээрх төлөвлөгөөнд хүүхэд, өндөр настан, тусгай хэрэгцээт иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр орон байраар хангах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хамгааллын асуудлыг тусгасан болно.</p> <p>2025 онд нийслэлийн хэмжээнд томоохон хэмжээний аюулт үзэгдэл, осол тохиолдоогүй болно.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
15	3.1.3.6.Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншейн, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах	-	Осол гэмтлийн буурсан хувь	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамжийн хүрээнд орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:</p> <ol style="list-style-type: none"> 1.Барилга байгууламж, худалдаа үйлчилгээ, 2.Зам, замын байгууламж, 3.Тохижилт, ногоон байгууламж, 4.дэд бүтэц, инженерийн байгууламж гэсэн 4 ангиллын хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулж 3,892 зөрчил илрүүлж, 1,368 зөрчлийг арилгасан. <p>Нийт зөрчлийг арилгах үүднээс нийслэлийн Засаг даргын 2025 оны А/560 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг засварлах, хотын стандартыг мөрдүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүргийн нийт 204 хороо тус бүрд</p>

	тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;				50.0 сая буюу 10.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 600 гаруй тохижилт, засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн байна. Эвдрэл гэмтэлтэй хүүхдийн тоглоомын судалгааг хийж, 52 байршилд засварын ажил хийхээр төлөвлөн 30 байршлын засварын ажлыг эхлүүлсэн, 22 байршлын худалдан авах ажиллагааг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байна. Нийтийн эзэмшлийн талбайд байрлах 35 тоглоомын талбайд эвдрэлтэй 12 төрлийн 304 тоглоом, хэрэгсэл, 16 автобусны буудал, 4666.1 метр хайс хашааг засварлах, нийтийн эзэмшлийн 4 байршилд тохижилт хийх шаардлагатай тооцоо судалгааг гарган засварлах асуудлыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газраас шийдвэрлүүлсэн. <i>Хэрэгжсэн</i>
16	3.1.3.7.Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.	-	Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна.	Өдөр өнжүүлэх төвийн нийтлэг шаардлага, хүүхэд харах үйлчилгээ, асрамж халамжийн төв, тоглоомын төв, түр хамгаалах байр, хүүхдийн зуслан зэргийн стандартын хэрэгжилтэд нийт 6 удаа хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6540:2015 стандарт, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүүхэд харах төвүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг сар бүр зохион байгуулан арга зүйгээр ханган ажиллаж байна. Зөрчил 42 хувиар буурсан. <i>Хэрэгжсэн</i>

3.2.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;

3.2.1.Хөдөлмөрийн харилцааны талаар:

17	3.2.1.1.Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;	-	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр нийт 254 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 1,808 ажил олгогчдын төлөөлөлд сургалтыг зохион байгуулсан. <i>Хэрэгжсэн</i>
18	3.2.1.2.Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	-	1.Хамрагдсан ААНБ-ын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна.	Бичил бизнес эрхлэгч 386 иргэнд аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага судлах арга хэмжээнд 35 иргэн, захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх 18 удаагийн сургалтад танхимаар 365 иргэн, нийт 786 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөр, “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд жижиг зээл олгох арга хэмжээний хөтөлбөр, төсөв батлагдаж ирээгүй байна. Түрээсийн болон борлуулалтын дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 4 иргэнтэй гэрээ байгуулсан. “Чингэлтэйд үйлдвэрлэв-3” борлуулалтын төвийн 2 салбарт нийт 18,3 сая төгрөгийн, үүнээс ХБИргэдийн үйлдвэрлэсэн

					<p>бүтээгдэхүүнээс 3,5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.</p> <p>Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төвөөс бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
19	<p>3.2.1.3.Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p>	-	<p>Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо</p>	<p>Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.</p>	<p>Нийслэл Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Нийслэлийн ажил олгогч эздийн холбооноос санал авч Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо байгуулах тухай” А/1462 дугаар захирамжийг боловсруулан санал авч, батлуулсан.</p> <p>Тус гурван талт хороонд төрийн байгууллагын төлөөлөл буюу НЗДТГ-аас гурав, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл буюу Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны төлөөлөл 3, ажил олгогч эздийн холбооны төлөөлөл 3 байна.</p> <p>Гурван талт хорооны 2 удаагийн хурлыг зохион байгуулж 3 хөдөлмөрийн сонирхлын маргаанд Арбитр томилох тогтоол гаргасан. Үүний дагуу 3 маргаан хэлэлцээрийн түвшинд амжилттай ажилласан.</p> <p>Мөн нийслэлийн хэмжээнд ажиллах арбитрчдын судалгаа танилцуулгыг нэгтгэн ГБХНХ-д хүргүүлээд байна.</p> <p>Мөн дүүргийн хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хорооны 81 гишүүнийг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх ажиллагааг мэргэжлийн түвшинд үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах хөдөлмөрийн</p>

					харилцааны маргааныг бууруулахад чиглэсэн чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан. <i>Хэрэгжсэн</i>
3.2.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:					
20	3.2.2.1.2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;	-	Бодлогын баримт бичгийн тоо,	Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна.	<p>Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллганы хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлвөлөгөө зэрэг бодлогын баримт бичигт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах зорилтуудыг тусгаад байна.</p> <p>2.3.Бүсийн хөгжлийн зорилттой уялдуулан зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.</p> <p>2.3.4.Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.3.5.Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.3.6.Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий тусгай бүс, төрөлжсөн байршлуудад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлыг байрыг нэмэгдүүлнэ.</p> <p>2.3.7.Нийслэлийн хэмжээнд ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>

21	3.2.2.2.Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;		Судалгаа, мэдээллийн тоо	Аймгийн (сум тус бүрээр) ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна.	<p>Нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.0 хувь, ажилгүйдлийн түвшин 5,6 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 58,3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажилгүйдлийн түвшин* 1,4 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин* 5,1 пунктээр, ажиллах хүчний оролцооны түвшин* 6,2 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр бий болсон ажлын байр -6024 - Ажлын байрны захиалга – 39971 - Зуучилсан иргэн – 5151 - Цагийн ажилд орсон -372 - ХБИ ажилд орсон -188 - Ажилгүйдлийн тэтгэмж-37722 - Хөдөлмөрт бэлтгэх сургалт-5915 <p><i>Хэрэгжсэн</i></p>
22	3.2.2.3.Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан	-	1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны	Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	<p>Үйлдвэрлэл технологийн паркууд (эмээлт- 5600, налайх-10.0, Багахангай -2100, багануур-2700) шинэ зуун мод, Налуу ухаа зэрэг тусгай бүсүүдэд ойролцоогоор 20,0-25,0 шинэ ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Нийслэлийн хэмжээнд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг үйл ажиллагаанд нийт 623 иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 501 иргэн, 372 оюутан залуучууд цагийн ажилд тус тус хамрагдсан байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>

	үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;		хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь		
23	3.2.2.4.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;	195,500,0	1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.	Нийгмийн халамж авагч 323 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилсан байна. -Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банк, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран “Төгсөлтийн аргачлал”, Дэлхийн зөн, “Холт” олон улсын байгууллага болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийт 12 хөтөлбөрийн хүрээнд 2,453 өрхийг хамруулсан байна. -Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Монголчууд монголчууддаа хөтөлбөрийн хүрээнд өөрийн гэсэн орон гэргүй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настантай 10 өрхөд иж бүрэн 5 ханатай гэр гардууллаа. Мөн төсөлд хамрагдсан өрхүүд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах, сурталчлах, харилцан туршлага солилцох өдөрлөг уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. <i>Хэрэгжсэн</i>

24	3.2.2.5.Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;	-	1.Холбогдох арга хэмжээний тоо 2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент (шинэ бүтээл, ашигтай загвар)-ын тоо	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан “Шилдэг Стартап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хүрээнд залуучуудад сургалт зохион байгуулахаар “Хөгжлийн шийдэл” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. <i>Хэрэгжээгүй</i>
25	3.2.2.6.Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	-	Холбогдох арга хэмжээний тоо	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна.	Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газрын чиг үүргийн Хөдөлмөр, халамжийн ерөнхий газарт шилжүүлснээр нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээ, хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үйл ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлууд саармагжсан ба зөвхөн бодлогын түвшинд ГБХНХ-ын сайдтай байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэж байна. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл байгуулах саналыг Нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбооноос авсан. Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн салбар зөвлөл байгуулагдан хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. <i>Хэрэгжээгүй</i>

26	3.2.2.7.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.	-	1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газрын чиг үүргийн Хөдөлмөр, халамжийн ерөнхий газарт шилжүүлснээр нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээг дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс үзүүлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 1,192,240,900 төгрөгийг төвлөрүүлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг олгох төслийн хүрээнд 80 иргэний төсөлд 654,0 сая төгрөгийг олгосон. <i>Хэрэгжсэн</i>
3.2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:					
27	3.2.3.1.Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал,	-	ХАБЭА-н тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх.	Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан. Мөн нийслэлийн Үйлдэрчний эвлэлийн холбооны харвьяа 64 байгууллага, нийслэлийн 3 дүүргийн 18 эрүүл мэндийн байгууллагад түүвэрчилсэн үзлэг зохион байгуулж дүгнэлт гарган, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулахаар

	эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;				ирүүлсэн 58 актыг баталгаажуулсан. <i>Хэрэгжсэн</i>
28	3.2.3.2.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд	-	1.Төлөвлөсөн төсөв 2.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийслэлийн зөвлөлийг шинэчлэн байгуулах санал авсан бөгөөд шийдвэрийн төслийг боловсруулсан. Нийслэлийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоотой хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг зохион байгуулж, 23 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд нийт 3,202 албан хаагч, иргэнийг хамруулж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан. <i>Хэрэгжсэн</i>

	чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;				
29	3.2.3.3.Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	-	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	Тухай бүр арга хэмжээ авсан байх.	2025 онд 62 үйлдвэрлэлийн осол бүргэгдсэн бөгөөд үйлдвэрлэлийн осол болсон аж ахуйн нэгж, байгууллагад ослын дараах сургалтыг зохион байгуулан эрсдэлийн үнэлгээг дахин хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. <i>Хэрэгжсэн</i>
3.3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.					
3.3.1.Нийгмийн даатгалын талаар:					
30	3.3.1.1.Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын	-	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-иас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Сайн дурын даатгалд 38,505 даатгуулагч иргэн хамрагдсан байна.

	байгууллагатай хамтран зохион байгуулах;				
31	3.3.1.2.Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	-	Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын 45,011 хувийн хэргийг цахимжуулсан.
32	3.3.1.3.Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд төрийн байгууллага хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, төсвийн байгууллага өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын	-	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	-	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Шимтгэл хураалт, удирдлага, арга зүйн газартай хамтран удирдамжийн дагуу 100 сая төгрөгнөөс дээш өртэй төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, өр барагдуулах гэрээ, албан шаардлага өгч, цаашид авлага үүсгэхгүй талаар анхааруулж, зөвлөмж өгч ажилласан. Нийт 46 төсөвт байгууллага өртэй байна.

	байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;				
33	3.3.1.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;	-	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна.	НД: Нийгмийн даатгалын газрын эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн эмч пүрэв гараг бүр “Мэдээллийн цаг”-аар Эрүүл мэндийн төвийн амбулаторийн эмч нар, болон 8 хороодын ерхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт танхимын сургалтуудыг зохион байгуулсан. Мөн Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын тоо хэмжээг бууруулах зорилгоор улирал тутам дахин магадлалын аяныг зохион байгуулж одоогийн байдлаар өмнөх жилийн тогтоолт 15-аар буурч цуцлалт 5 хувиар нэмэгдсэн байна. БЗД: Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр 8696 иргэний эрүүл мэндийн байдалд дүн шинжилгээ хийж шинээр 1024 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож 615 хүнийг цуцалж, 7626 сунгаж шийдвэрлэлээ. ХУД: Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр 562 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтаа шинээр тогтоолгож, 1,492 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтаа сунгуулсан байна.
34	3.3.1.5.Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна.	-

3.3.2.Нийгмийн халамжийн талаар:

35	3.3.2.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	315,081.8	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	2025 онд нийслэлийн 9 дүүрэгт Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 3666 хүн хамрагдаж 1,394,181,059 төгрөг зарцуулсан. Хэрэгжсэн.
36	3.3.2.2.Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;	49,000,0	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн хамгааллын тусгай төв нь 2025 онд нийт 783 орон гэргүй зорилтот бүлгийн иргэнийг түр хоноглох байранд хүлээн авч байрлуулан нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан ажилласан байна. Энэ хугацаанд 15 иргэнийг бичиг баримтжуулж, 3 иргэнийг ахмад настны асрамжид шилжүүлж, эрүүл мэндийн анхан шатны үзлэгт 715 иргэн, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 355, эрүүл мэндийн яаралтай тусламжид 25, архины сайн дурмын эмчидгээнд 28, эмнэлэгт хэвтүүлэх үйлчилгээнд 172 иргэнийг тус тус хамруулж, хөгжлийн сургалт 61 удаа зохион байгуулан 1825 иргэнийг (давхардсан тоо) хамруулж,

					сэтгэл зүйн оношилгоонд 353, ганцаарчилсан зөвлөгөөнд 343, бүлгийн зөвлөгөөнд 715 иргэн хамруулж, тогтвортой болон түр ажлын байранд 265 иргэнийг хамруулан, 31 иргэнийг бие даасан амьдралд шилжүүлэн ажилласан байна. <i>Хэрэгжсэн</i>
37	3.3.2.3.Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах.	4,300,0 3,3360,	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 2.Сургалтын тоо	Нийгмийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар сайжирсан байна.	Хорооны, эрүүл мэндийн нийгмийн ажилтан болон хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор арга зүйн сургалтыг 23 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 475 нийгмийн ажилтанг хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Хамтарсан багаар ажиллах ажил үйлчилгээ үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх сургалт”-д 204 хорооны нийгмийн ажилтнуудыг хамруулсан. Нийт 5 удаагийн кейс хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 215 хорооны нийгмийн ажилтан, албан хаагч, “Нийгмийн хамгааллын алхмууд, кейс менежментийн арга зүй”, “Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх арга зүй” сэдэвт сургалтад “Хүүхэд хамгаалагч” төслийн 30 албан хаагчийг хамрууллаа. “ОУ-ын дэлхийн нийгмийн ажилтнуудын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн салбар дундын нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын дунд хүүхэд хамгааллын салбарын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг дэмжих зорилготой “Social work conference - 2025” арга хэмжээг зохион байгуулж, нийт 350 гаруй албан хаагчдыг хамруулсан. <i>Хэрэгжсэн</i>
3.3.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:					

38	3.3.3.1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	-	Сургалт	30-аас доошгүй	<p>Тайлант хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн сургалт болон арга хэмжээг 80 удаа зохион байгуулж, 3700 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Нийслэлийн Замын хөгжлийн газартай хамтран зам завсарын ажил эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, удирдах албан тушаалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүний ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоог сайжруулах зорилгоор “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ-ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ” сургалтыг зохион байгуулсан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
39	3.3.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	20	<p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дэмжих” бүлэг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийн өөрчлөлтийг сурталчлан таниулах, мэдээллээр хангах, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор “ИРГЭДТЭЙ САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ”-ыг зохион байгуулж, нийт 400 гаруй иргэд оролцсон.</p> <p>Багахангай дүүргээс хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулан 12 иргэнийг хамруулсан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
40	3.3.3.3.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон	-	Зохион байгуулсан сургалтын тоо	3	<p>-“Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв 29 дүгээр сургуулийн үе тэнгийн сургагч багш нартай хамтран Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн ариун цэвэр, Бэлгийн замаар дамжих</p>

	нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;				<p>халдвараас урьдчилан сэргийлэх сэдвийн хүрээнд 2 удаагийн сургалт зохион байгуулж, 58 сурагч хамруулсан.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд хүсээгүй бэлгийн харьцаанд орох эрсдэлээс сэргийлэх, өөрийгөө хайрлах талаарх сургалтыг зохион байгуулан 1400 эмэгтэйчүүдийг хамруулсан.</p> <p>-БГДЭМТ, ХУДЭМТ, ЧДНЭ, БЗДЭМТ-үүд хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны 870 эмэгтэйг үзлэгт хамруулж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгосон.</p> <p>-БГДЭМТ, СХДЭМТ нь 2,846 аутизмтэй хүүхдийн эцэг, эхчүүдэд аутизмыг ойлгох тухай боловсрол олгох сургалт зохион байгуулсан.</p> <p>-Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв 19, Бяцхан тэмүүлэл хүүхдийн сэргээн засах төв 300, Хантуул хүүхдийн сэргээн засах төв 279 нийт 598 аутизмтэй хүүхэд эмчийн хяналтад эмчлүүлж байна</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
41	3.3.3.4.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд төрийн болон ТББ-тай хамтран ажиллах;	-	Дэмжих төв	1	<p>Сонгинохайрхан дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс, “Монголын Сайн Дурынхны Төв” Төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байдаг хүүхдийн нөхцөл байдлыг үнэлэх, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлж, хүүхэд бүрийн ялгаатай байдалд тулгуурлан хөгжлийн үйлчилгээг хүргэх замаар эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Анд” төслийг хэрэгжүүлэх гэрээг байгуулсан бөгөөд 20 хүүхдийг сонгон авч, төслийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.</p>

					<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа “Хөгжлийн туслалцаа” ТББ-ын үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 3 иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хувийн хэргийг нээж, баталгаажуулан хүргүүлсэн.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэсэн “Ай эй пи инсайт” ХХК-ийн үзүүлсэн үйлчилгээнд 352 иргэн хамрагдсан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
42	3.3.3.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх,	5,500,0	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	<p>Ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийг түшиглэн нэг өрөөг тохижуулан шаардлагатай тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлээр ханган комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй “Хамтран ажиллах” санамж бичиг байгуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах цэцэрлэгийн эмч, багш зэрэг 35 хүнийг сургалтад хамруулж, чадавхжууллаа.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалын салбар комиссын хурлаар 5,395 хүүхдийг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
43	3.3.3.6.Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	<p>“Гал түймрийн үед авах арга хэмжээ”, “Байгалийн гамшигт үзэгдэлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөсрдийгөө хэрхэн хамгаалах талаар болон анхны тусламж”, “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх”</p>

	бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх				<p>зэрэг сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 55 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан.</p> <p>Гамшгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БХД-4 сургууль, СБД-27 сургууль, ХУД-3 сургууль, НД-5 сургууль, 2 спорт заал, зочид буудлын зориулалттай 3 барилга, амралт, сувиллын 20 байгууллага, нийт 64 байгууллагын барилга байгууламжийг хоргодох газраар бүртгэн хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн орчны аюулгүй байдлыг хангаж, гал түймрийн эрсдэлийг бодитоор бууруулах зорилгоор ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургууль, 186 дугаар цэцэрлэгт гал түймэр унтраах анхан шатны 6 төрлийн 213 ширхэг багаж, техникийн хэрэгсэл хүлээлгэн өгч, ашиглалтын зааварчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөмжийг хүргэсэн.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
44	3.3.3.7.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	<p>ХУД: Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 496,955,000 төгрөгийг төвлөрүүлээд байна.</p> <p>СХД: Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүйн төлбөрт 29,370,000 төгрөг төвлөрүүлээд байна.</p> <p>БГД: 59.300,000 төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн 56 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.</p> <p>НД:Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй 3 аж ахуйн нэгж байгууллагаас 4,567,200</p>

					<p>төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.</p> <p>БЗД: Хөдөлмөрийн хуулийн 144 зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 42,284,000 төгрөг төвлөрүүлсэн байна.</p> <p>СБД: Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн дагуу 243,455,520 төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.</p> <p>ЧД: 238,900,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.</p> <p>БНД: Хөдөлмөрийн хуулийн 144 зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 78,408,000 төгрөг төвлөрүүлсэн байна.</p> <p>БХД: 3,0 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
45	3.3.3.8.Хөдөлмөрийн хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	-	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	3	<p>Нийт 5 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийт 1,353 иргэнд 27.9 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
46	3.3.3.9.Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	-	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	5	<p>СБД:Нийгмийн халамжийн үйл ажиллагаа, хууль, эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ний мэдээллийг аудио тайлбартай дохионы хэлмэрчтэй бэлтгэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон 25 хорооны цахим хуудсанд байршуулан иргэдэд хүргэж байна.</p> <p>СХД:Харааны бэрхшээлтэй иргэдийн цахим мэдээллийн орчныг хүртээмжтэй болгох төрийн үйлчилгээ үзүүлдэг 5 байгууллагад “NVDA” буюу дэлгэц уншигч программыг суурилуулсан.</p>

					Дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс “Нэг цонхны үйлчилгээний заал”-ны 1 номерын цонхыг шинээр нээж, Хөгжлийн бэрхшээлтэй (зорилтот бүлгийн) иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, таних тэмдэг тэмдэглэгээ, брайл үсгэн гарын авлага, үзэг бал, харааны шил зэргийг байршуулж, төрийн үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангасан. <i>Хэрэгжсэн</i>
47	3.3.3.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	23.9 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжид НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв хувь	90	Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс нь иргэдэд үйлчилгээний зааврыг брайл үсгээр хэвлүүлэн стандартыг ханган ажилласан. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилгоор хөтөч тектель шал, брайл үсэгтэй хаяг, дохионы хэлмэрч бүхий АI цахим хөтөч, дуудлага хүлээн авах тусгай дугаар, тусгай хэрэгцээт иргэдтэй харицах ажилтныг томилон ажиллуулж байна. Хан-Уул дүүгийн Эрүүл мэндийн төв нь үзүүлж буй үйлчилгээг АI ашиглан цахим хэлбэрээр иргэдэд хүргэж байна. Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс комиссын хурлыг цахимаар зохион байгуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй ажиллаж байна. <i>Хэрэгжсэн</i>
48	3.3.3.11.Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна			3	Нийслэлийн хэмжээнд 11 байршил 34,620 м2 явган хүний замыг завсарлан шинэчилсэн байна.

	<p>байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;</p>				<p>СХД: 333, 332, 340 дүгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын 169 дүгээр сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, орц гарц, бие засах газар, брдюрийн налуу зэргийг стандартын дагуу хүртээмжтэй болгосон.</p> <p>ХУД: Эрүүл мэндийн төв эмчийн үзлэгийн өрөөний хаягжилтыг брайль үсэгтэй болгосон бөгөөд, тектель зам, AI виртуаль хөтчийг давхар бүрд шинээр нэвтрүүлж, цахим бүртгэлийн хэсэгт тусгай хэрэгцээт дуудлага авах дугаар, мөн ажилтныг ажиллуулж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар AI виртуаль хөтчид 1548, тусгай хэрэгцээт дуудлагад 28 иргэн хандсан байна.</p> <p>БГД: Эрүүл мэндийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн.</p> <p>СБД: Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Сэлбэ эмнэлэгийн 1, 2 дугаар давхруудад харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч зам, Брайль үсгэн дуугүй хөтөч чиглүүлэх ном байршуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх угтах ажилтан, эмч, эмнэлгийн ажилчдад зориулсан дохионы хэлний сургалт, дохионы хэлний аппликейшн суулгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн тохируулгат орчны хүртээмжийг нэмэгдүүлсэн. Дүүргийн нэг цонхны үйлчилгээгээр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, жирэмсэн болон бага насны хүүхэдтэй иргэдэд зориулан өрөө гаргаж, засварлан, хүүхэд хуурайлах тавцан, зөөврийн ширээ, буйдан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан салбар зөвлөлийн мэдээллийн самбар, брайль болон хөгжлийн бэрхшээлийн ойлголтыг нэмэгдүүлэх номнууд, анхны тусламжийн гарын авлага, төрөл бүрийн танин мэдэхүй, соёлын ном,</p>
--	--	--	--	--	--

					<p>хүүхдэд зориулсан зурагт, англи хэлний номнуудаас бүрдсэн номын тавиур, сандал, зөөлөн дэвсгэр, анхны тусламжийн эмийн хайрцаг, нэг удаагийн аяга, ариун цэврийн хэрэглэлүүд, ханын шүүгээ зэргээр тохижуулж ээлтэй орчныг бүрдүүлж ажилласан.</p> <p>НД: Дүүргийн худалдааны төвийн дөрвөн замын уулзварын явган хүний гарцад сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын хэвтээ гэрлэн дохио, худалдааны төвийн дөрвөн замын уулзварын явган хүний гарцад 8 ширхэг дуут дохиог суурилуулсан. Мөн 7 дугаар хорооны байранд налуу замыг тавьсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд саадгүй үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн стандартын налуу зам, угаалгын өрөө, зориулалтын суултуураар үйлчилж хэвшсэн.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
49	3.3.3.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.	25,0	Хөгжлийн төвийн тоо	1	<p>Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг байгуулсан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
3.3.4.Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:					
50	3.3.4.1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт,	-	1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	5-аас доошгүй удаа байгуулсан байна.	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 2024 оны тайланг нэгтгэн гаргаж Жендэрийн үндэсний хороонд хугацаанд хүргүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Хүний хөгжлийн хороонд танилцуулж тайлагнасан.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хүрээнд 6 зорилт, 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр</p>

	мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.				<p>нийслэлийн салбар хорооны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Нийслэл дэх жендэрийн салбар хорооны бүрэлдхүүнийг шинэчлэн батлуулж, салбар хорооны хурлыг 2025.11.07 зохион байгуулсан.</p> <p>Иргэд, олон нийтийн дунд жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ талаар иргэдийн чиг хандлагыг ямар түвшинд хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Миний гэр бүл дэх аав, ээжийн оролцоо” гар зургийн уралдаан, дунд ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, их дээд сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд болон ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдаан Өнөөгийн нийгэм дэх “Жендэрийн эрх тэгш байдал миний нүдээр” сэдэвт уралдааныг зохион байгуулж, шалгаруулсан.</p> <p><i>Хэрэгжсэн</i></p>
3.3.5.Ахмад настны талаар:					
51	3.3.5.1.Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	-	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	Ахмад настны тухай хуулийн хэрэгжүүлтийг хангах зорилгоор 100 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, нийт 8500 албан тушаалтныг хамруулсан.
52	3.3.5.2.Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх	-	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.	Нийт 75 төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага ахмадын сан, 130 байгууллага тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

	төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;		2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо		Хэрэгжсэн
53	3.3.5.3.Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	24,9	1. Баталсан төсвийн хэмжээ (сая.төг) 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна.	<p>Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх “Ахмадын өргөө” нь ахмадуудыг хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орчинд нь мод тарьж зүлэгжүүлсэн. Дүүргийн 3 дугаар хороонд 40 м² талбай бүхий “Ахмадын танхим”-ыг шинээр байгуулан тохижуулж, үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн 5 дугаар хороонд 75 м² талбай бүхий “Ахмадын чийрэгжүүлэлтийн танхим”-ыг тохижуулсан.</p> <p>Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 277 м² талбай бүхий 2 давхар Ахмадын хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулсан. Тус төв нь ахмадуудад зориулсан соёл, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах урлаг заал, өдөр өнжүүлэх болон сэргээн засах танхимтай.</p> <p>Багануур, Багахангай дүүргийн Ахмадын төвөөр давхардсан тоогоор 5000 гаруй ахмад настан үйлчлүүлсэн.</p> <p>Сонгинохайрхан дүүргийн “Ахмадын хөгжлийн төв” нь хороодын ахмад настануудад өдрийн болон явуулын үйлчилгээг үзүүлж зөвлөгөө мэдээллээр хангах, тэдний чөлөөт цагийг ая тухтай өнгөрүүлэх зорилгоор шатар, даам, дартс, дуу хөгжим сонирхогчдын бүлэг ажиллуулж давхардсан тоогоор 1649 гаруй ахмадыг хамруулсан.</p>

					“Ахмадын өргөө” нь ахмадуудыг хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зориулалтаар үйл ажиллагаа явуулж байна. <i>Хэрэгжсэн</i>
54	3.3.5.5.Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	-	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна.	Ахмад настуудын эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэц, сэтгэл зүй, бие бялдарын нөхцөл байдалд цогц үнэлгээ хийх цогц үйлчилгээ, хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэсэн үнэлгээнд 2,000 гаруй ахмад настныг хамруулсан. Кейс менежментийн шинэлэг тогтолцооны сургалтыг өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтнууд, хорооны нийгмийн ажилтнууд, ахмадын зөвлөлийн дарга нарт 2 удаа зохион байгуулж, нийт 100 гаруй төрийн албан хаагчид, ахмад настууд оролцлоо. <i>Хэрэгжсэн</i>
55	3.3.5.6.Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг	15,0 сая	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна.	6079 ахмад настныг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Үзлэгт хамрагдсан ахмадыг насны ангиллаар авч үзэхэд: 56-65 насны 2553 ахмад, 66-75 насны 2441 ахмад, 76-85 насны 959 ахмад, 86-аас дээш насны 126 ахмад байна. Дүүргийн эмнэлгийн хяналтад авсан ахмадын тоо 1432, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт лавлагаа шинжилгээнд хамруулахаар шийдсэн ахмадын тоо 863 байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас үнэлгээний үр дүнд үндэслэн хараа болон сонсголын чадвар бууралттай ахмадуудыг эрүүл мэндийн төвтэй холбосон ба өдрийн эмчилгээ, гэрийн эмчилгээ, сувилгаанд 7,983, сэргээн засах эмчилгээд 21,393 тус тус хамрагдсан байна.

	тогтмолжуулж, хяналт тавих;				Улсын нэгдүгээр төв эмнэлэг, "Сайн Учрал" сан, БНСУ-ын "Южин оптикал" нүдний эмнэлэгүүд Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран "Тунгалаг мэлмий" аянг 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Аяны хүрээнд тус дүүргийн 600 иргэнд хараа зүйн цогц оношилгоо, зөвлөгөө авч, харааны шил тохируулах үйлчилгээ үзүүлсэн. Үзлэгт хамрагдсан хүн бүрд тохирсон харааны шилийг БНСУ-д үйлдвэрлэн 2025 оны 10-11 дүгээр сард ахмадад хүлээлгэн өгсөн. <i>Хэрэгжсэн</i>
56	3.3.5.7.Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний	15,000,000	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Нийслэлийн Ахмадын хороотой хамтран хойч үедээ үлгэр дууриал болсон "Тэргүүний өрх", Ахмад тариланч", "Бүтээлч ахмад"-ыг шалгаруулан алдаршуулсан. Хэрэгжсэн

	сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;				
57	3.3.5.8.Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлэх;	24,000,000	1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая төг)	Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.	Нийт 14 ахмад настанд оршуулгын тэтгэмжийн 28,000,000 төгрөгийг зарцуулсан байна. <i>Хэрэгжсэн</i>
58	3.3.5.9.Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад	-	50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Нийт 1443 ахмад хөдөлмөр эрхэлж байна. Тайлант хугацаанд Түр ажлын байраар хангах болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 632 ахмад хамрагдсан байгааг дүүргээр авч үзвэл: Багануур дүүрэгт-85, Багхангай дүүрэгт-16, Баянгол дүүрэгт-63, Баянзүрх дүүрэгт -104, Налайх дүүрэгт-29, Сонгинохайрхан дүүрэгт-106, Сүхбаатар дүүрэгт-26, Хан-Уул дүүрэгт -125, Чингэлтэй дүүрэгт-78 байна. <i>Хэрэгжсэн</i>

<p>настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих;</p>		<p>тоо</p>		
<p>Хэрэгжилтийн дундаж дүн</p>				<p>92</p>

ХЯНАСАН:
НЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

Ш.АНХМАА

НЭГТГЭСЭН:
НЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

М.НАМСРАЙХҮҮ